



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 5/37.

Ховд

Ж.Дамдинбазарыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 05/12935 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Жамъянжавын Дамдинбазарыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн Булган сумын Засаг даргаар томилсугай.

2. Ж.Дамдинбазарт Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 1015984 төгрөг /Нэг сая арван таван мянга есөн зуун наян дөрөв/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцон сар бүр бодож олгохыг Булган сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Ш.Азжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Ж.Дамдинбазарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-B/37-Bo